

БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖИЙН ХЯЗГААРЛАЛТ

А.Солонго⁷ (PhD), Жендэрийн үндэсний шинжээч, МУИС-ийн ШУС, профессор

Д.Оюунханд, Судалгааны багийн ахлагч

А.Цолмонтуяа, Б.Туяа, Г.Гэрэлцэцэг, Б.Чимгээ, С.Сарангэрэл, Судалгааны багийн гишүүд

Хураангуй

Бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөв санхүү хязгаарлагдмал, мэргэшсэн банк, санхүүгийн байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг төрөөс бодлогоор дэмжин хэрэгжүүлж буй аливаа төсөл хөтөлбөрийн хүрээнд зээл хүртээмжгүй байна. Иймд бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд зээлд хамрагдаж чадахгүй байгаа учир шалтгааныг тодорхойлон, бодит байдлыг дүрслэн харуулах зорилготой энэхүү кейс судалгааг хийсэн.

Судалгааг чанарын судалгааны арга зүйгээр хийсэн. Судалгаагаар зээлийн шалгуурууд нь бичил бизнес эрхлэгчдийн онцлогт тохироогүй, тэдгээрт чиглэсэн бичил зээл, санхүүгийн дэмжих тусгай арга хэмжээ байхгүй, Засгийн газраас АХБ-ны санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ХААН банк, Төрийн банкаар дамжуулан эмэгтэйчүүдийн дэмжих зээлийг олгож байгаа боловч бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд тусгайлан зориулагдаагүй, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдахад тодорхой шалгуур тавигддаг хэдий ч засаг, захиргааны нэгжийн төлөөлөл бүхий дэд зөвлөлөөр дамжиж байгаагаас субъектив хүчин зүйл нөлөөлж байгааг илрүүлсэн.

Түлхүүр үгс: бичил бизнес, барьцаа хөрөнгө, зээлийн баталгаа, зээлийн шалгуур

Abstract

LIMITATIONS ON ACCESS TO LOANS FOR WOMEN ENTREPRENEURS IN MICRO BUSINESS

Female micro-business owners have limited investment and budget to sustain their business while specialized banks, financial institutions, and employment are not available within the framework of any projects and programs implemented by the government. Therefore, this case study was conducted with the aim of identifying and illustrating the reality of why women micro-entrepreneurs are unable to access loans.

The study was conducted by qualitative research methodology. According to the research, the loan criteria do not match the characteristics of micro-entrepreneurs and there are no micro-loans or special financial supports aimed at them. Plus, under the ADB funded government project framework, women's support loans are provided through the Khan Bank and the State Bank, but only to those engaged in micro-entrepreneurs. Although certain criteria are set for participation in projects and programs that are not specifically designed for employment support, small and medium industry, and service support, subjective factors have been found to be influenced by sub-councils with representatives of government and administrative units.

Key words: *Micro-business, collateral, credit guarantee, credit criteria*

⁷ Холбоо барих зохиогч. Хаяг: solongo_a@num.edu.mn

1. УДИРТГАЛ

Үндэслэл

Монгол Улсад улсын бүртгэлтэй 80 орчим мянган аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 86 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) байна. ЖДҮ-ийн дийлэнх (59%) нь жилийн 50 хүртэлх сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчид⁸ юм⁹.

Монгол банкны мэдээллээр 2022 оны эцсийн байдлаар¹⁰ ЖДҮ-д олгосон зээлийн 36.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд зээлдэгчдийн бараг гуравны хоёр нь эрэгтэй бизнес эрхлэгчид байна. Дунджаар нэг зээлдэгчид ногдох зээлийн үлдэгдэл эрэгтэй бизнес эрхлэгчийн хувьд 89.87 сая төгрөг, эмэгтэй бизнес эрхлэгчийн хувьд 49.28 сая төгрөг байна.

ЖДҮ эрхлэгчдэд төсөл хөтөлбөрөөр дамжуулан олгосон зээлийн үлдэгдлийн 44 хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчид ногдож байна. Сонирхолтой нь эрэгтэй бизнес эрхлэгчдийн зээлийн 8.4% нь чанаргүй (хэвийн бус, эргэлзээтэй, муу) зээлийн ангилалд шилжсэн бол эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд үзүүлэлт 3.5% буюу даруй 2-с илүү дахин доогуур байна. Эндээс эмэгтэй бизнес эрхлэгчид эрэгтэй бизнес эрхлэгчидтэй харьцуулахад бага дүнтэй зээл авч байгаа хэдий ч зээлийн эргэн төлөлт, хариуцлагатай байдал илүү сайн байна гэдгийг харж болно.

Түүнчлэн, ААН-д нэгжид олгогдсон зээлийн ердөө 19.2% нь эмэгтэй захиралтай ААН-д, иргэдэд олгосон зээлийн ердөө 17% нь эмэгтэйчүүдэд ногдож байна. Харамсалтай нь “эмэгтэй эзэнтэй бизнес” эсвэл “албан бус бизнес” гэдэг тодорхойлолтыг холбогдох хуулиудад зааж өгөөгүй бөгөөд албан болон албан бус бизнес бүртгэлийн мэдээллийн

санд хүйсээр ангиллагдсан нарийвчилсан мэдээлэл хомс байна¹¹.

ЖДҮ эрхэлж буй эмэгтэйчүүдэд олгогдсон зээлийн 46.7% нь бөөний болон жижиглэн худалдаа, 10% нь боловсруулах үйлдвэрлэл, 7.3% нь барилга, 4.2% нь зочид буудал, байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, 2.8% нь хөдөө аж ахуйн чиглэлд ноогдсон байна.

Хүн амын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүтээмжтэй аж ахуй эрхлэлтийг дэмжих, зорилтот бүлгийн иргэдийн аж ахуй эрхлэх чадавхыг дээшлүүлэх замаар бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Уг туршилтийн хөтөлбөрийг нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд жижиг зээлийг ХААН банк, Төрийн банкуудаар дамжуулан олгож байна.

ЖДҮ-ийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эмэгтэйчүүд, тэр дундаа бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөв санхүү хязгаарлагдмал, мэргэшсэн банк, санхүүгийн байгууллагаас төдийгүй хөдөлмөр эрхлэлтийг төрөөс бодлогоор дэмжин хэрэгжүүлж буй аливаа төсөл хөтөлбөрийн хүрээнд ч зээл хүртээмжгүй байна.

2014 оны байдлаар¹² ЖДҮ-д шаардлагатай, хангагдаагүй зээлийн эрэлтийн хэмжээ 5 тэрбум ам.доллар байсан бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийн зээлийн эрэлт 25%-ийг эзэлж байжээ. Хэдийгээр эмэгтэйчүүд банканд бүх төрлийн данс эзэмшиж байгаа ч¹³, эмэгтэйчүүдийн авч буй зээлийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс бага байна. Тухайлбал, эмэгтэйчүүд нийт зээлдэгчдийн 57%-ийг

⁸ ХНХЯ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт тодорхойлсноор, 50.0 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн.

“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-д тодорхойлсноор, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг; мөн 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг ойлгоно.

⁹ <https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol201830.pdf>

¹⁰ Монголбанк (2023). Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээл, хүйсээр www.mongolbank.mn

¹¹ https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/09/Covid-19-Impact-Assessment-on-Micro-and-Small-scale-Women-Business-Enterprises-in-Mongolia_MG.pdf

¹² ОУСК (2014). Монгол Улс дахь ЖДҮ ба Эмэгтэй ЖДҮ эрхлэгчид

¹³ Дэлхийн банк (2017). Findex Data.

эээлж байгаа ч нийт зээлийн 43%-ийг авсан байна¹⁴.

Монгол эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмжийг олон бэрхшээлүүд хязгаарлаж байгаа бөгөөд эмэгтэйчүүд өөрсдийн нэр дээр бүртгүүлсэн өмч, хөрөнгөгүй тул барьцаа хөрөнгө шаарддаг зээл авахад тун хүндрэлтэй байна¹⁵.

Иймд эмэгтэйчүүд бид (бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүд ороод) хэлэлцэн зөвшилцөж, бичил бизнес эрхлэхэд тулгарч буй хөрөнгө, санхүүтэй асуудлыг дараахь байдлаар тодорхойлсон. Үүнд:

- *Зээлийн барьцаа хөрөнгө* - газар, мал, орон сууц гэх мэт өөрийн эзэмшлийн биет капитал байхгүй эсвэл дутагддаг.
- *Бизнес эрхлэх гарааны хөрөнгө* байхгүй эсвэл дутагддаг.
- Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэн явуулах өөрийн өмчлөлийн ажлын байр байдаггүй, дийлэнхдээ өөрийн амьдардаг гэртээ эсвэл түрээсийн төлбөр өндөр өрөө, тасалгаа, байр ашигладаг.
- Бариа, материалын *эргэлтийн хөрөнгө* авах боломжгүй, ялангуяа үнийн өсөлт, Ковид19 цар тахлын нөлөөгөөр нийлүүлэлт хомсдсон, улмаар эрэлт нэмэгдсэн.
- Шаардлагатай *техник, тоног төхөөрөмж* худалдан авах, шинэчлэн сайжруулах, шинэ технологи нэвтрүүлэх хэрэгтэй болдог.

Судалгааны асуудал: *Банк, ББСБ, ЖДҮ-ийн сангийн зээлээс бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд яагаад хүртэж чадахгүй байна вэ?*

Судалгааны зорилго, зорилтууд

Бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд зээлд хамрагдаж чадахгүй байгаа учир шалтгааныг тодорхойлон, бодит байдлыг дүрслэн харуулахад энэхүү кейс судалгааны зорилго оршино. Дээрх үндсэн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Арилжааны банк, ББСБ, ЖДҮХ-ийн сангийн зээлийн шалгуурууд, барьцаа хөрөнгийн хэлбэр, төрлийг харьцуулах;
2. Эмэгтэйчүүд бичил зээлд хамрагдаж чадахгүй байгаа учир шалтгааныг кейсээр нотлон харуулах;
3. Кейсийн нотолгоонд тулгуурлан эмэгтэйчүүдийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх санал зөвлөмж боловсруулах.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


2.1 Судалгааны загвар

Судалгаанд чанарын судалгааны арга зүй, загварыг ашигласан. Сэдвийн хүрээ, зорилгод нийцүүлэн шинжилгээний нэг нэгж ба олон кейсийн нэгжүүдийн судалгааны дизайныг сонгосон болно. Кейсийн нэгж нь арилжааны банк, ББСБ, ЖДҮХ-ийн сангаас зээл авч байсан болон зээл авч чадаагүй бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд байсан.

2.2 Дүн шинжилгээний хүрээ ба таамаглал

Судалгааны багийн гишүүд бид асуудлыг тодруулах хэлэлцүүлэг, баримтын судалгаанд үндэслэн бичил бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд зээлд хамрагдаж чадахгүй байгаа учир шалтгааныг доорх дүн шинжилгээний агуулгын хүрээнд шинжилсэн (Бүдүүвч 1).

Бүдүүвч 1. Дүн шинжилгээний агуулгын хүрээ



¹⁴ Үндэсний статистикийн хороо (2020). Нэгдсэн мэдээллийн сан, 1212.mn

¹⁵ Азийн сан (2022). Монгол Улсын санхүүгийн салбарын жендэрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлага, Улаанбаатар

Таамаглал:

H₁: Зээлийн барьцаа хөрөнгийн төрөл, хэлбэр нь бичил бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд зээл авах боломжийг хязгаарладаг.

H₂: Зээлийн мэдээлэлгүй, зээлийн үйлчилгээний чанар муу байгаагаас бичил бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд зээлд хамрагдаж чаддаггүй.

2.3 Кейсийн сонголт

Эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийг харгалзан кейсийн анхдагч нэгжийг сонгов (*Хүснэгт 1*).

Хүснэгт 1. Судалгааны нэгж, түүврийн хэмжээ

Судалгааны нэгж		Тоо
Бичил бизнес эрхэлдэг эмэгтэй		3
1	Үйлдвэрлэл ба худалдаа салбар /хот/	2
2	Үйлдвэрлэл-мөнгөн хуримтлалын бүлэг /хот/	1
Гол мэдээлэгчтэй хийх ганцаарчилсан ярилцлага		3
1	ББСБ-ын эдийн засагч	1
2	ЖДҮ-ийн сангийн мэргэжилтэн /аймаг/	1
3	ХЭДС-ийн мэргэжилтэн /аймаг/	1
Нийт		6

2.4 Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 1 сарын 5-наас 2 сарын 6-ны өдрүүдэд Улаанбаатар хот болоод Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд зохион байгуулсан.

Гол кейсээр сонгогдсон бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүд Улаанбаатар хот болон орон нутагт үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр эдийн засгийн засгийн үйл ажиллагаанд оролцогчид байв. Мөн банк, санхүүгийн байгууллагын зээлийн 1 эдийн засагч, орон нутагт ажиллаж буй холбогдох төрийн 2 албан хаагчидтай ганцаарчилсан ярилцлага хийсэн.

3. АРИЛЖААНЫ БАНК, ББСБ, ЖДҮ-ИЙГ ДЭМЖИХ САНГААС МӨРДӨЖ БҮЙ ЗЭЭЛИЙН ШАЛГУУРУУД

Энэ хэсэгт Арилжааны банк, ББСБ, ЖДҮ-ийн сангийн зээлийн шалгууруудыг харьцуулан, эмэгтэйчүүдийг дэмжсэн зээлийн бодлого, үйлчилгээ байдаг эсэхийг тодруулж, үр дүнг тоймлон харуулж байна. Эдгээрийн мэдээллийн эх үүсвэрийг *Шигтгээ 3.1*-д харуулсан.

Шигтгээ 3.1 Зээлийн шалгуурын талаарх мэдээллийн эх үүсвэр

- Монголбанк www.mongolbank.mn
- Голомт банк www.golomtbank.com
- Худалдаа хөгжлийн банк www.tdbm.mn
- Хаан банк www.khanbank.mn
- Төрийн банк www.statebank.mn
- Хас банк www.xacbank.mn
- Санхүүгийн зохицуулах хороо www.frc.mn
- Инвескор ББСБ www.invescore.mn
- Транскапитал ББСБ www.transcapital.mn
- ЖДҮХСан www.sme.gov.mn
- ХХҮЕГ-ийн төсөл хөтөлбөрүүд www.hudulmur-halamj.gov.mn

3.1 Арилжааны банкуудын зээлийн шалгуурууд ба эмэгтэйчүүдийг тусгайлан дэмжих арга хэмжээ

➤ ХААН Банк:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх;
- Сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх;
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх;
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх;
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх;
- Бусад.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих

ХААН банк бизнесийн болон төслийн зээлүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчийг тусгайлан тодотгож, нэмэлт шаардлага тавигдаагүй байна.

Харин эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, сургалт зөвлөх үйлчилгээгээр хангах, бизнес консалтингийн үйлчилгээ үзүүлж байна.

➤ Төрийн банк:

- Сүүлийн 6 сар тасралтгүй тухайн бизнесийг эрхэлсэн туршлагатай;
- Бизнесийн тогтмол мөнгөн урсгалтай, үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлогын 70%-иас хэтрэхгүй дүнгээр зээл, зээлийн хүүг хуваарийн дагуу хэсэгчлэн төлөх чадвартай;
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий холбогдох байгууллагаас авсан;
- Сүүлийн 1 жилийн /улирлын/ санхүүгийн тайлан;
- Зээлийн барьцаанд өөрийн өмчлөлийн эсхүл гуравдагч этгээдийн барьцааны зүйлийг тавих, батлан даалт, банкны баталгаатай;
- Чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих

Төрийн банк бизнесийн болон төслийн зээлүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчийг тусгайлан тодотгож, нэмэлт шаардлага тавиагүй байна. Гэхдээ тусгай хөтөлбөр зээлийн бүтээгдэхүүнд зээлийн хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгож байна. Жишээлбэл Төрийн банкаар дамжуулан тусгай "Save Green" кредит карт борлуулах ажил эхэлсэн мөн Ковид-19 цар тахлын гамшгийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрыг дэмжих зорилгоор Засгийн газраас хүүгийн хөнгөлөлт үзүүлэх, Зээлийн батлан даалтын сангаас Монгол Улсын холбогдох хуульд нийцүүлэн батлан даалт гаргах банкны өөрийн эх үүсвэрээр түр хугацааны 500 сая хүртэлх зээлийг эмэгтэйчүүдэд зориулан гаргаж байжээ.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг *Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй эсвэл эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүдэд* бараа материал худалдан авах болон үйл ажиллагааны ашиг, орлогоо нэмэгдүүлэх зориулалтаар авах боломжтой. Ингэхдээ дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй байх;
- Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 66.7%-аас дээш хувийг эмэгтэй хувьцаа эзэмшигч эзэмшдэг, гүйцэтгэх удирдлага нь эмэгтэй байх;
- Нөхөрлөлийн гишүүдийн 66.7%-аас дээш хувь нь эмэгтэй гишүүд байх;
- Хоршооны гишүүдийн 66.7%-аас дээш хувь нь эмэгтэй гишүүд байх ба хоршооны дарга нь эмэгтэй гишүүн байх;
- Сүүлийн 6 сарын турш тасралтгүй бизнес эрхэлсэн туршлагатай байх;
- Нөхөрлөл, хоршооны хувьд аль нэг гишүүн нь сүүлийн 6 сар тухайн бизнесийг эрхэлсэн туршлагатай байх.

Барьцаа хөрөнгө болон зээлийн хүүний хувьд хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгож байна. Ерөнхий зээлийн нөхцөлүүдээс хөнгөлөлттэй зээлийг олгож байна.

➤ **Худалдаа хөгжлийн банк (ХХБ):**

- Зээлийн өргөдөл;
- Улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Компанийн дүрэм;
- Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүндмөн адил хамаарна);
- Түрээсийн гэрээ, дансны хуулга, бараа материалын үлдэгдэл;
- Гэрлэлтийн гэрчилгээ (гэрлээгүй бол гэрлэсэн эсэх лавлагаа);
- Бусад шаардлагатай бичиг баримт (үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз г.м).

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих

ХХБ бизнесийн болон төслийн зээлүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчийг тусгайлан тодотгож, нэмэлт шаардлага тавигдаагүй байна.

ХХБ нь өөрийн боловсруулсан тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Олон улсын хөрөнгө оруулалтын банктэй хамтран ажиллаж 15 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээг амжилттай байгуулсан. Энэхүү санхүүжилт нь байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтнууд давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт санал болгож Монгол Улсын тогтвортой хөгжлийг дэмжин, улс орны эдийн засгийн сэргэлтэд үнэтэй хувь нэмрийг оруулах зорилготой. Ингэхдээ доорх шаардлагын аль нэгийг хангасан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн 51% ба түүнээс дээш хувьд эмэгтэй хувьцаа эзэмшигч байх;
- Эмэгтэй гүйцэтгэх/ерөнхий захиралтай байх;
- Нийт ажилтнуудын 50% ба түүнээс дээш эмэгтэй ажилтнууд байх.

➤ **Голомт банк:**

- Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын

иргэн, Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх;

- Сүүлийн 12 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх;
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх;
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх;
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх;
- Бусад.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих

Голомт банк бизнесийн болон төслийн зээлүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчийг тусгайлан тодотгож, нэмэлт шаардлага тавиагүй байна.

Харин бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг *Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй эсвэл эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүд* бараа материал худалдан авах болон үйл ажиллагааны ашиг, орлогоо нэмэгдүүлэх зориулалтаар авах боломжтой.

Барьцаа хөрөнгө болон зээлийн хүүний хувьд хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгож байна. Ерөнхий зээлийн нөхцөлүүдээс хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийг олгож байна. Түүнчлэн Голомт банкны хэрэгжүүлж буй олон төрлийн санхүүжилтийн хөтөлбөрүүд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон нийт зээлийн хэмжээ 20%-аар өсжээ. Зээлийн хэмжээ сүүлийн таван жилийн дунджаас 30%-иар өссөн байна. Түүнчлэн сүүлийн гурван жилд эмэгтэй зээлдэгчийн тоо 26%-аар өссөн байна¹⁶.

➤ **Хас банк:**

- Сүүлийн 6 сарын хугацаанд тухайн бизнесийн үйл ажиллагаагаа явуулсан байх;
- Тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан, зөвшөөрөл нь зээл төлөгдөж

¹⁶ Жилийн тайлан 2020, Голомт банк

дуусах хүртэл хүчин төгөлдөр байх эсхүл тодорхой хугацаагаар олгогддог тусгай зөвшөөрлийн хувьд цаашид сунгагдах боломжтой байх;

- Бусад банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд муу зээлийн түүхгүй байх;
- Бизнесийн орлого зарлагаа тогтмол хөтөлдөг ба бүртгэл /хуулийн этгээдийн хувьд нягтлан бодох бүртгэл/ хөтлөлт нь тухайн бизнесийн үйл ажиллагааны тухай бодит мэдээллийг илэрхийлэх боломжтой байх;
- Зээлдэгч банкнаас шаардсан материалыг үнэн зөв, бүрэн гаргадаг байх;
- Зээл хүсэгч бизнес хийх явцдаа хуулийн этгээд байгуулан үйл ажиллагаа явуулж байсан бол уг хуулийн этгээд нь дампуурсан эсхүл муу зээлийн түүхгүй байх;

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих

Хас банк бизнесийн болон төслийн зээлүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчийг тусгайлан тодотгож, нэмэлт шаардлага тавиагүй байна. Тусгай хөтөлбөр зээлийн бүтээгдэхүүнд зээлийн хөнгөлөлттэй нөхцөлийг санал болгож байна. Тухайлбал, Банк 2017

онд ОУСК болон Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпорацаас (ХЧХХОК) эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих зорилгоор 169 сая ам.долларын санхүүжилт татжээ. Энэхүү санхүүжилт нь ХЧХХОК-ийн 2022 оны 3 дугаар сар гэхэд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн боломжийг дэмжих сан (БЭБДС) – ийн хүрээнд ЖДҮ эрхлэгч эмэгтэйчүүдэд 100 сая ам.долларын санхүүжилт олгож байжээ.

Азийн сангаас боловсруулсан Монгол Улсын Санхүүгийн салбарын жөндөрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлагын шалгуур үзүүлэлт, нөхцөл

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээлд тавигдах шалгуур эдгээр банкуудын хувьд нийтлэг боловч компанийн хувьцаа эзэмшигчдэд тавигдах шаардлагын хувьд бага зэрэг ялгаатай байна. Тухайн арилжааны банкны цахим хаягуудад байгаа мэдээллүүд шинэчлэгдээгүй байна. Азийн сангаас 2022 онд боловсруулсан гарын авлагад заасан зээл хүсэгчид тавигдах ерөнхий шалгууруудыг банкууд хэрхэн хэрэглэснийг *Хүснэгт 2.1* ба *Хүснэгт 2.2*-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 2.1. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээлд тавигддаг шалгуурууд, сонгосон банкуудаар

Банкууд	Шалгуур үзүүлэлтүүд
ХХБ	- Эмэгтэй хувьцаа эзэмшигч >51% - Эмэгтэй гүйцэтгэх захирал эсхүл ерөнхий захирал - Эмэгтэй ажиллах хүчний хувь >50%
Голомт	- Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй - Удирдлага дахь эмэгтэй төлөөлөл - Эмэгтэй хувьцаа эзэмшигч >51% - Удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх удирдлагын баг дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл >30% - Нөхөрлөл эсхүл холбооны гишүүнчлэл дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл >51%, Холбооны дарга нь эмэгтэй байх - Эмэгтэй ажиллах хүчний хувь >51%
Төрийн	- Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй - Эмэгтэй хувьцаа эзэмшигч >66.7%, гүйцэтгэх захирал эмэгтэй байх - Нөхөрлөл эсхүл холбооны гишүүнчлэл дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл >51%, Холбооны дарга нь эмэгтэй байх
Богд	- Эмэгтэй хувьцаа эзэмшигч >51% - Удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх удирдлагын баг дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл >30% - Нөхөрлөл эсхүл холбооны гишүүнчлэл дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл >51%, Холбооны дарга нь эмэгтэй байх - Эмэгтэй ажиллах хүчний хувь >50%

Хүснэгт 2.2. Зээлийн нөхцлүүд

Нөхцөлүүд	ХХБ	Голомт	Төрийн	Богд
Зээлийн хэмжээ	<1 тэрбум төгрөг	<100 сая төгрөг	<50 сая төгрөг	<100 сая төгрөг
Зээлийн хүү	12%	12-15.6%	15.6%	15.6%
Хугацаа	<36 сар	<36 сар	<24 сар	<36 сар
Барьцаа	Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө	- 1-12 сар: Дансны орлого - 13-24 сар: Тоног төхөөрөмж, бараа материал - 25-36 сар: Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө	Тодорхойгүй	Тодорхойгүй
Шимтгэл	Мэдээлэл олдоогүй	0.5%	1%	0.5%
Үндсэн төлбөрөөс чөлөөгдөх хугацаа	12 сар эсхүл хугацааны 1/3 хүртэл	12 сар эсхүл хугацааны 1/3 хүртэл	Мэдээлэл олдоогүй	6 сар
Олгож эхэлсэн огноо	2021 оны 11 дүгээр сар	2021 оны 6 дугаар сар	2020 оны 8 дугаар сар	2021 оны 12 дугаар сар

Эх үүсвэр: Азийн сан, 2022. Монгол Улсын Санхүүгийн салбарын жөндөрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлага

3.2 Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн шалгуур

Банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ) нь санхүүгийн салбарын 4.9%-ийг эзэлдэг бөгөөд арилжааны банкны дараа орж буй хамгийн том зээлдүүлэгч юм. 2021 оны III улирлын байдлаар 531 ББСБ 2.5 их наяд төгрөгийн актив, 1.6 их наяд төгрөгийн зээлийн багцтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос дүрмийн санг 2.5 тэрбум төгрөгт хүргэх шаардлага тавьж, дижитал зээл олгож эхэлсэнтэй холбоотойгоор ББСБ-ууд санхүүгийн харьцангуй тааламжтай нөхцөлд хөгжиж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны сайтад эмэгтэйчүүдэд зориулсан бизнесийн зээл болон санхүүжилтийн талаар албан ёсны мэдээлэл, статистик байхгүй байна. Гэхдээ бид томоохон хоёр ББСБ-ын зээлийн шалгуурыг судалж үзсэн юм. Мөн түүнчлэн Монгол Улсын Санхүүгийн салбарын жөндөрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлагад орсон ББСБ-уудын нэгтгэсэн мэдээллийг ашиглалаа (Хүснэгт 3). Үүнд:

➤ Инвескор ББСБ:

- Барьцаа хөрөнгө болон орлого хүрэлцэхүйц байх;
- 6 болон түүнээс дээш сар үйл ажиллагаа явуулсан байх

Инвескор ББСБ нь бизнесийн зээлийн нөхцөлд эрэгтэй, эмэгтэй гэж үйлчлүүлэгчдийн хүйсээр тусгайлан заасан шаардлага байхгүй, эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа зээлийн бүтээгдэхүүн байхгүй байна.

➤ Транскапитал ББСБ:

Нарийвчилсан шаардлага тавигдаагүй. Бизнесийн зээлийн нөхцөлд эрэгтэй, эмэгтэй гэж үйлчлүүлэгчдийн хүйсээр тусгайлан заасан шаардлага байхгүй, эмэгтэйчүүдэд зориулсан тусдаа зээлийн бүтээгдэхүүн байхгүй байна.

Хэдийгээр Топ ББСБ-ууд эмэгтэйчүүдэд тусгайлан зориулсан зээлийн бүтээгдэхүүн олгодоггүй ч БЖДҮ, ногоон, хэрэглээний болон цахим зээлийн бүтээгдэхүүнийг хүйс харгалзахгүйгээр 60 хүртэлх сарын хугацаатай сарын 1.5% болон түүнээс дээш хүүтэй 500 сая төгрөг хүртэлх ерөнхий нөхцөлтэй зээл олгож байна. Зээлийн шаардлагаар ерөнхийдөө үл хөдлөх хөрөнгийг барьцаанд авдаг байна.

Хүснэгт 3. ББСБ-уудын зээлийн бүтээгдэхүүнүүд

ББСБ	Эмэгтэй бизнес эрхлэгчдийн зээл	Бичил бизнесийн зээл	ЖДҮ зээл	Ногоон зээл	Хэрэглээний зээл	Дижитал зээл
Инвескор	+	+	+		+	+
Транскапитал		+	+	+	+	
Жи Эс Би Капитал						+
Ашид Капитал		+	+			+
Централ Капитал		+	+		+	+
БИД		+	+	+	+	+
ДэндМН						+
Очир-Ундраа ОМЗ		+	+	+	+	
Нэткапитал		+	+		+	+
Их Агдир					+	

Эх үүсвэр: Азийн сан, 2022. Монгол Улсын Санхүүгийн салбарын жөндөрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлага

3.3 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (шинэчилсэн найруулга, 2019)-ийн 11 дүгээр зүйлд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх

сан (ЖДҮХС)-гаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг Засгийн газар хариуцан зохион байгуулахаар заасан байна. ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын¹⁷ дагуу ЖДҮДС-гаас зээл олгох процесс явагдаж байна. Процессын зураглалыг доор харуулав.



Эх сурвалж: Азийн сан, Жөндөрийн Үндэсний Хороо, 2023. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах нь

¹⁷ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020.03.25-ны өдрийн 113 дугаар тушаалын хавсралт

ЖДҮХС-гийн арилжааны банкаар дамжуулан олгож буй зээл нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд зээлийн шалгаруулалтын үйл явц ил тод биш, мөн арилжааны банкны шалгуур их өндөр гэж гарч байна.

Тус сангаас бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 300.0 сая төгрөг хүртэл төгрөгийн зээлийн нэг удаа тус сангаас шууд олгохоор заажээ.

Харин дараах нөхцөлд хөнгөлөлттэй зээл олгохгүй байхаар хуульчилсан байна. Үүнд:

- Сангаас авсан зээлийн үлдэгдэлтэй;
- Зээлийн мэдээллийн санд муу зээлийн түүхтэй;
- Сангаас авсан зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон;
- Шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өртэй;
- Төсөл хүлээн авах сүүлийн өдрийн байдлаар нийгмийн даатгал, татварын байгууллагад өртэй.

3.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (шинэчилсэн найруулга, 2011)-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулах талаар тусгайлан заасан. Тус хуулийн хэрэгжүүлэлтийн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл жил бүр тогтоол гаргаж, тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах эмэгтэйчүүдэд зээлийг зөвхөн Аймгийн Хөдөлмөр Халамж, Үйлчилгээний Газар, Дүүргийн Хөдөлмөр, Халамж, Үйлчилгээний Хэлтсээр дамжуулан олгогддог.

2022-2023 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тавигдсан шалгуур:

- Ажилгүй эмэгтэйчүүд
- Гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд
- Хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд
- Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй

- Өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй эмэгтэйчүүд
- Мэргэжлийн сургалтын байгууллага
- Ажил олгогч байгууллагуудад 10 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Дээр мэдээллийг харьцуулсан үр дүнгээс харахад бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд банк, санхүүгийн холбогдох байгууллагуудын зүгээс тэдгээрт чиглэсэн бичил зээл, санхүүгийн дэмжих тусгай арга хэмжээ байхгүй байна. Харин төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдахад тодорхой шалгуураас гадна засаг, захиргааны нэгжийн төлөөлөл бүхий зөвлөлөөр дамжиж байгаагаас субъектив хүчин зүйлийн нөлөө их байж болох талтай байна.

4. ЭМЭГТЭЙЧҮҮД БИЧИЛ ЗЭЭЛД ХАМРАГДАЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА УЧИР ШАЛТГААН

Кейс 1. Бичил бизнесийн эхлэл ба хөрөнгө оруулалтын хомсдол, зээлийн хүртээмж

Бичил бизнесийн гараа

...Т нь 50 настай, нөхөр 2 хүүхдийн хамт, Хан-Уул Дүүргийн 11-р хороонд 15 дахь жилдээ амьдарч байна. Тэрээр 1992-1996 онд УБДС-ийг нийгмийн багш мэргэжлээр дүүргэж, зах зээлийн шилжилтийн үед давхар зах дээр наймаа хийдэг байсан. 1996 онд анхны хүүхдээ төрүүлж, нөхөртэйгээ хамт наймаа эрхэлж байгаад 2000-2004 онд БНСУ-ыг зорьж, агаар шүүгчийн үйлдвэр, сандлын үйлдвэрт ажиллаж байгаад ирсэн. Тэнд ажиллаж хадгалсан мөнгөөрөө монголдоо байр авч, үлдсэнгээр нь амьжиргаагаа залгуулж, ажил хайж эхэлсэн. Ажил хайж байх хугацаандаа Солонгосын хувийн компанид менежерийн албан тушаалд ажиллаж байтал компани дампуурч ажилгүй болсон. Улмаар 2 удаа хувийн үйлдвэрлэл эхлүүлэх гээд амжилтгүй болсон. Ингэж байтал 2 дахь хүүхдээ төрүүлсэн. Хажуугаар нь 2005-2008 онд нягтлан мэргэжлээр СЭЗДС-ийн Бямбын ангийг дүүргэсэн. 2013-2017 оны хооронд Солонгосыг дахин зорьж, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрт 3 жил ажилласан. Гэр орон, үр хүүхдүүд маань монголд байсан болохоор удаан хүний нутагт байж чадаагүй, буцаад нутагтаа ирсэн. Тэнд ажиллаж байсан туршлагаа ашиглан 2017 оны хагас жилээс Ногооны Шүүсний Брэнд нэрийн доор 5 төрлийн бэлдмэл боловсруулахаар ажиллаж хураасан мөнгөөрөө үйлдвэрлэлийнхээ анхны хөрөнгө оруулалтыг хийж, үйлдвэрлэлээ эхлүүлсэн. Монголдоо тогтвортой ажлын байртай,

тогтвортой орлоготой байх нь маш чухал байсан тул энэ бизнестээ нөхрөө татан оролцуулсан. Энэ бичил бизнесийг эхлүүлээд одоо амьдарч байгаа хороондоо үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаад 6 дах жил рүүгээ орж байна. Үйлдвэрийн байр 120 м.кв талбайтай, 2017 оноос хойш түрээслэж байна...

Зээлийн хэрэгцээ

... Анх борлуулалтаа сайн хийж чадахгүй байсан тул эргэлтийн бэлэн мөнгөний хэрэгцээ нэлээд хэрэгтэй болсон. Өмнө нь зээл авч байсан туршлагагүй байсан болохоор банкнаас зээл авдаг гэсэн ойлголт ч байгаагүй. 2017 онд 1 сая гаруй төгрөгийг ломбарднаас сарын 4.5%-ийн хүүтэй, авч хагас жил орчим хүүгээ төлж, зээлийн хугацаагаа сунгадаг байсан.

Харьцангуй хямд үнээр бүтээгдэхүүний сав баглаа боодлыг олон тоогоор захиалахын тул ББСБ-аас 2017 онд 10 сая төгрөгийг сарын 2% хүүтэй /жилийн 24% хүү/ зээлж байсан. Фэйсбүүкээр УБ банкны нэг давхарт БЭЭТөвийн мэдээлэл явж байхыг хараад тус төвөөс зохион байгуулдаг үйл ажиллагаанд хамрагдаж бизнесийн мэдлэг, ур чадвараа сайжруулж, бизнес эрхлэлтийн мэдлэг, мэдээлэл олж авсан. Тухайлбал, бүтээгдэхүүнээ борлуулах, зээлийн мэдээллийн талаар ойлголттой болсон. Улмаар Голомт банкаар дамжуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 18 сарын хугацаатай жилийн 8.4% хүүтэй 20 сая төгрөгийн зээлд 2018 онд хамрагдаж чадсан. Энэ зээлээ хугацаандаа маш сайн төлж чадсан тул банкинд сайн түүхтэй болж дараа дараагийн зээл авах боломж нээгдэж, Голомт банкнаас эргэлтийн хөрөнгийн 18% хүүтэй 20 сая төгрөгийн зээлийг 2019, 2020 онуудад авч байсан.

Мэдээллийн хомсдол, баримт бичиг бүрдүүлэлт

...Миний эрхэлж буй энэ үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гар ажиллагаа их байдаг тул ажилчин тогтож ажиллах хүндрэлтэй байдаг. Тоног төхөөрөмжөө нэмж авах, баглаа их хэмжээгээр захиалан өртгөө бууруулах үүднээс ЖДҮГазрын ЖДҮ дэмжих сангийн зээлд хамрагдахаар сонирхож, хүмүүсийн ам дамжсан яриагаар 9-с дээш ажилчинтай компанид өгдөг гэж сонсоод хүсэлт, материалаа өгч чадаагүй. Дараа жил нь зээлд хамрагдахад шаардлагатай материалыг судалж, нилээн их бичиг цаас бүрдүүлэх хэрэгтэй болсон. Төсөл бичих, бичиг баримтын бүрдүүлэлт төвөгтэй, ажиллагаатай санагдсан. Миний бие бичил өрхийн үйлдвэрлэл явуулдаг, хүн хүч муутай учир өглөө 4 цагт босож үйлдвэрлэлээ 4:30 эхлэн 10:30-11:00 үед дуусаад борлуулалт, түгээлт, хүргэлт гээд бүх юмаа өөрөө хийнэ. Замын ачаалал, түгжрэл гайгүй бол 17 цагийн үед дуусаад гэртэй ирж хоол унд, гэрийн ажлаа хийсээр унтдаг. Ажлын 7 өдөр шахам ажиллаж байж л түрээс зээлийн ард гардаг. Төслийн бичиг

баримт бичиг бэлтгэх зав гарахгүй байсан. Банкны мэргэжилтнээс хөнгөлттэй зээлийн мэдээлэл авч байгаагүй. Мэдээллийг олон улсын төсөл, Фейсбүүкээс л авдаг...

Зээлийн баталгаа ба барьцаа хөрөнгө

...Нийслэлийн Жижиг Дунд Үйлдвэрлэл Үйлчилгээний газраас “Цар тахлын нөлөөнд өртсөн Улаанбаатар хотын ЖДҮҮ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” богино хугацааны сургалт 2022 оны 10-р сарын 5—наас эхэлсэн. Миний бие компани төлөөлөн 1-р ээлжийн сургалтад бүрэн хамрагдаж, хөнгөлөлттэй зээл авах болсондоо маш их баяртай байсан. Хөнгөлөлттэй зээл нь 36 сарын хугацаатай эхний 3 сар үндсэн зээлээс чөлөөлөн үлдсэн саруудад үндсэн зээлээ хүүтэй нь төлөх цагаа олсон зээл байсан.

Манайх 80 сая төгрөгийн зээл авахаар төлөвлөн уг зээлээр зарим гар ажиллагаатай ажлыг тоног төхөөрөмж шинэчлэх, шинэ бүтээгдэхүүнд зориулсан тоног төхөөрөмж, баглаа боодолны захиалгыг хийхээр төлөвлөж байсан. Барьцаа хөрөнгөд тавихаар өөрийн нэр дээрх зуслангийн газар, орон нутагт байх өмчлөлийн газар, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө, өөрийн нэр дээрх хөрөнгө оруулалт болох урт хугацаатай бондыг барьцаалан хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй байсан. Уг зээл Ариг банкаар олгогдохоор болсон ба банкны барьцаанд үл хөдлөх хөрөнгө, хөдлөх буюу автомашин барьцаанд авах журамтай гэсэн.

Бичил бизнесийн цех маань ХУД 11-р хороо “Оргил Рашаан Сувилаал” ХХК байранд түрээсийн байранд байршдаг. Нийт 74 дахь сардаа түрээслэж байна. Түрээсийн төлбөрөө сарын бүрийн 5 дотор хариуцлагатайгаар төлж байгаа баталгаа байсан хэдий ч барьцаа хөрөнгөнд орлуулах боломжгүй гээд банкнаас татгалзсан. Өмнө авч байсан зээлээ хуваарийн дагуу хариуцлагатай төлж байсан. НДШ, ААНОТ зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа найдвартай, тогтвортой явагдаж, үүргээ цаг хугацаандаа хариуцлагатайгаар төлдөг байсан ч энэ бүхэн зээлийг хариуцлага авч, төлөх нотолгоо, дэмжлэг болж чадаагүй...

Бизнесийн хэтийн төлөв ба зээлд хамрагдах сонирхол

...Хан-Уул дүүрэг ЭКО дүүрэг гэсэн бодлогын хүрээнд эмэгтэй бичил бизнес эрхлэгч миний хувьд хариуцлагатайгаар хаягдал цаас, гялгар уут, хуванцараа ангилан “Түвшин Сайхан” төв дээр өөрийн унаагаар хүргэн өгдөг, өөрийн үйлдвэрээс гардаг ногооны хаягдал, шахдасаа компост бордоо болгон ногоон байгууламжийг нэмэгдүүлж байгаа цехдээ хог хаягдлын менежментээ “Өнгө Нэм”ТББ-с зөвлөх үйлчилгээ авч хэрэгжүүлж, сард гардаг ахуй хогны хэмжээгээ багасгах, ангилан ялган дадлыг нэвтрүүлж байна. Энэ ч утгаар нийгмийн хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэгч гэж

боддог.

Миний бие өөрийн ажлын байртай болох чин эрмэлзэлтэй. Ямар нэг ажлыг хийхдээ төрийн бодлого, стандарт, хууль дүрмийн дагуу хийхийг хичээдэг. Монгол Улсын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй танилцан аж үйлдвэрийн парк, хүнсний үйлдвэрийн бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөнд шүүс, нухашны үйлдвэрлэл Дархан-Уул аймагт төвлөрөх төлөвлөгөө байгааг олж мэдээд, энэ талаар нэлээд судалж байна. Өөрийн ажлын байраа Улаанбаатараас орон нутаг руу шилжүүлэн хийхээр төлөвлөж, өөрт байгаа багахан хэмжээний мөнгийг банкаас ахиу өгөөжтэй хөрөнгөөр баталгаажсан урт хугацаатай бондод хөрөнгө оруулсан. Гэвч Ариг банкны барьцаа хөрөнгийн журамд үл хөдлөх хөрөнгө нь орон сууц, хөдлөх хөрөнгө буюу автомашин гэсэн нь ЖДҮ үйлдвэрлэгчдэд тохиромжгүй, зээлийн зорилгын чигээ оноогүй санагдсан.

Хөрөнгө оруулалтаа барьцаалан зээл авах боломжгүй байгаа нь хөрөнгө оруулагч болох боломжгүй, харин үл хөдлөх орон сууцтай л байх ёстой мэт сэтгэгдэл төрүүлж байна. Арилжааны банкууд шалгууртаа хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэгч гэдэгт ач холбогдол өгөхгүй байгаа нь хөрөнгөтэй ч хариуцлагагүй үйлдвэрлэгч, хүнийг дэмжиж байгаа мэт санагдсан. Барьцаа хөрөнгө нь орон сууц гэдэг болохоор 3 дахь этгээдийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавих хэрэгтэй болдог. Гэтэл хамаатан садан, найз нөхөд болон бусад хувь хүмүүсийн хооронд мөнгөн тохиролцоо хийхийн тулд авилга хахууль өгөх асуудал тулгардаг тул барьцаа хөрөнгөд тааруулж алдагдал бас зээлийн эрсдэлд орохоос өөр арга зам дахиад л хайх хэрэг удаа дараа гардаг...

Кейс 2. Зээлийн шалгуур ба баримт материал бүрдүүлэлт

Бичил бизнесийн гараа ба зээлийн хэрэгцээ

...Бизнес эрхлэгч Г, нөхөр хүүхдийн хамт Сонгинрохайрхан дүүрэгт амьдардаг. Тэрээр 1976 онд Барилгын Техник Мэргэжлийн Сургуулийг төгсөөд мэргэжлээрээ 25 жил тасралтгүй ажиллаж байгаад 2004 онд тэтгэвэрт гарсан. 2004 онд сарын 320,000 төгрөгний тэтгэвэр авдаг амьдралд хүрэлцэхгүй (2022 оны хувьд тэтгэвэр 500,000 төгрөг байгаа), өрхийн орлого хүнд байсан учраас Дэлхийн зөнгөөс зохион байгуулдаг сургалтуудад хамрагдаж, 2010 онд 4 хүнтэй "Ирээдүй бүлэг"-ийг үүсгэн оёдлын цех байгуулсан. Энэ хугацаанд Дэлхийн зөнгийн 3 удаагийн уралдаанд түрүүлж 3 ширхэг цахилгаан машинтай болсон. Энэ дээрээ үндэслээд 2012 онд "Хайнаг толгой" хоршоог 9 хүнтэйгээр оёдол, гутал, модон эдлэл, худалдаа үйлдвэрлэлийн бизнес эхлүүлж, одоог хүртэл үйл ажиллагаа хэвийн, тайлан тооцоогоо цаг хугацаанд өгөөд явж байна.

Одоо манайх 12 гишүүнтэй болж оёдол гутал,

арвайн гурил, модон эдлэл чиглэлээр үйлдвэрлэлээ үргэлжлүүлж байна. Хоршооны ажлын байр маань хоршооны хамтын үйлдвэрлэлийн байранд байрладаг. Хоршооны ажлын байраа 2 давхар болгох, ажилчдынхаа цалин хөлсийг тавих, үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнээ хадгалах агуулах савтай болох, түүхий эд материалаа авах зэрэг олон санхүү, хөрөнгө мөнгөний хэрэгцээ шаардлага байнга гардаг. Банк, санхүүгийн байгууллагууд, төрөөс гаргаж буй зээлийн хөтөлбөрүүдэд хамрагдаж, зээл олж авах гэж их хөөцөлдсөн...

Зээлд хамрагдсан байдал ба зээлийн шалгуур, баримт материал бүрдүүлэлт

...Анх 2018 онд өөрийнхөө тэтгэврийн зээлийг авч үзсэн. Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэхээр хүрэлцээ муу, маш бага зээл байсан. Иймд бүтээгдэхүүн, бараа материал, түүхий эдээ худалдан авах зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаас 1 удаа "Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв"-өөр дамжуулж 5,0 сая төгрөгийн эргэн төлөлттэй, 4.9%-ийн хүүтэй зээл олж авсан.

...Үүний дараагаар 2019 онд дахин ХЭДС-д хандахад тус сангаас ахмадуудад дахин зээл өгөхгүй гэсэн шалтгаанаар өгөөгүй. Харин ХЭДС-аас дэмжих захиа хийж өгч тухайн үед Капитал банкны "Хоршоо нөхөрлөлдэмжих" 10 сая төгрөгийн зээлд хамруулах санал өгсөн. Шалгуурын дагуу бүх материалаа бэлдээд Капитал банкинд өгсөн боловч бараг 3 сарын дараа хариу хэлээд ахмад настанд өгөхгүй гэдэг шалтгаан хэлсэн, өөр ямар нэгэн нэмэлт тайлбар огт хэлээгүй.

Бусад банк, санхүүгийн байгууллагаас зээл хүсэхэд 2-3 сарын дараа тэтгэврийн насныханд зээл өгөхгүй гэсэн. Мөн барьцаа хөрөнгө шаардсан.

БЭЭТ-ээс мэдээлэл авснаар 2020 онд Төрийн банкнаас цахимаар 10 сая төгрөгийн зээлийг жилийн 8.9%-ийн хүүтэйгээр авсан. Хүүхдүүд маань материал бүрдүүлэхэд их тусалдаг. Хувь хүнээр зээл гарахгүй учир эдийн засагч нь ААН-ээр бүртгүүл гэж зөвлөсөн. Гишүүд бүхэн өр зээлгүй байх ёстой, тэдгээрийг нотлох гэх мэт маш их материал бүрдүүлсэн. Группын зээлтэй байсан хөгжлийн бэрхшээлтэй гишүүнээ олох гэж бас удсан. Ковид19 цар тахалын хөл хорио зэргийн үеэр иргэний бүртгэлтэй холбоотой мэдээлэл, тодорхойлолт, нас барсан гишүүний мэдээлэл олж авч бүх гишүүдийнхээ материал, мэдээлэл бүрдүүлнэ гэдэг настай миний хувьд их хүндхэн байсан.

2021 онд ЖДҮ-ийн 3%-ийн зээлд хамрагдахаар материалаа өгсөн боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан бичиг байхгүй гэдэг шалтгаанаар хассан гэсэн. Уг нь бэлтгэсэн материалуудад тодорхойлолт авахад тушаасан 10.0 төгрөгийн баримтын хамт хавсаргаж өгсөн байсан.

Ингээд арга бараад 2021 онд Хөгжлийн Шийдэл ТББ-аар дамжуулан Инвест кор ББСБ-аас 24 сарын хугацаатайгаар 10 сая төгрөгний зээлийг олж авсан. Өөрсдөө ирж үзээд дүгнэлт хийгээд барьцаанд хашаа байшингаа тавиад, 4.9%-ийн хүүтэй зээлд хамрагдсан.

2022 онд дахин ЖДҮ-ийн 3%-ийн зээлд хамрагдахаар материалаа өгсөн боловч 6 сард 3-р эмнэлгээс оёдлын захиалга аваад 14 сая төгрөгний борлуулалтын орлоготой болж, НӨАТ 1.4 сая төгрөг гарсан байсан. Үүнийг хараад өртэй байна гээд хассан байсан. Өрийн талаар өөр мэдээлэл байгаагүй. Зээлд шаардлагатай баримтуудыг цахимаар илгээсэн бөгөөд 2 сарын дараа өөрөө утасдан лавлаж асуухад дээрх шалтгааныг хэлсэн. Уг нь энэхүү НӨАТ-ын асуудал нь зээлийн шалгуур биш, тухайн үедээ ийм гарсан гэдэг нь зээлд нөлөөлөх ёсгүй гэж бодож байна.

Ингээд дахин 2022 онд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвөөр дамжуулан Нөмөр ББСБ 5 сая төгрөгийн зээлийг 3.5%-ийн хүүтэйгээр 24 сарын хугацаатай авсан.

Арилжааны банкуудаас хөнгөлттэй зээлийн талаар мэдээлэл авч байгаагүй, ажлын ачаалал ихтэй, өөрөө үйлдвэрлэл дээрээ байнга ажилладаг болохоор санхүү, зээлийн мэдээллээс хоцорсон байдаг, хажуугаар нь бичиг цаасны ажил хүндрэлтэй байдаг.

ББСБ харьцангуй гайгүй хурдан гардаг ч гэсэн араас нь маш их гүйж байж зээлд хамрагдаж байсан. ...

Кейс 3. Бичил бизнес эрхлэлт ба мөнгөн хуримтлалын зээл

...Өрхийн бизнес эрхлэгч С нь 2018 онд тэтгэвэртээ гарсан, бэлэвсэн. Тэрээр 11 настай хүү, хоёр хөгжлийн бэрхшээлтэй дүү нарын хамт 4-үүлээ Хан-Уул дүүрэгт хашаа байшинд амьдардаг. Тэрээр хашаандаа 7 чацарганы мод, 4 үхрийн нүдний мод, 1 мойлны модоо тарьж зуны улиралдаа жимсээ хураан бүлгийн гишүүддээ борлуулан энэхүү ажлаа бизнес болгон хөгжүүлэх чин хүсэлтэй ч асаргааны ажил их тул сүүлийн 6 жилийн хувьд олон нийтийн үйл ажиллагаанд орох боломж хомс болж улирлын шинжтэйгээр борлуулж байна. Тэрээр 2005 оноос хойш мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүнээр тогтвортой байж иржээ. Хүний Эрх хөгжлийн төвөөр дамжуулан анх 2005 онд Тайланд улсын туршлагаар мөнгөн хуримтлал бүрдүүлэх ажлын хүрээнд энэхүү бүлэгт бага хэмжээний зээл болоод сургалт орсноор мөнгөн хуримтлалын бүлгийн хуримтлалын ажил дээшилж ирсэн. Анх өдрийн 100 төгрөгөөр гишүүд мөнгөн хуримтлал хийж эхэлсэн ба түүнийг хэрхэн удирдах талаар дэмжлэг авч байсан.

Тэрээр мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүддээ олгодог 500,000-2,000,000 төгрөгийн зээлийг 1.5-3 хувийн хүүтэй 3-12 сарын хугацаатайгаар

тогтмол авч хашаа байшингаа засах, нойлоо сайжруулах, мод тарих, жимсний мод суулгах, хүүхдийн сургалт дугуйлангийн төлбөр төлөх зэрэг зорилготойгоор олон жил зарцуулсан байна. Бүлгийн зээлийн шалгуур их хялбар байсан. Учир нь шалгуурын хувьд гэвэл би өөрөө 2005 оноос хойш бүлгийн гишүүнээр тогтвортой байсан, мөн сүүлийн 5 жил тэтгэврийн орлоготой тул баталгаа болдог, мөн бүлгийн гишүүд маань намайг таньдаг мэддэг тул зовлонгүй хурдан багахаан зээлээ авч амьжиргаагаа залгуулчихдаг. Ер нь дүрмийн дагуу бүлгийн зээлийг дараах зорилгоор өгдөг i) орон байрны нөхцөл сайжруулах, ii) гишүүдийн орлого нэмэгдүүлэх, iii) улирлын чанартай зээл олгох, iv) оюутны сургалтын төлбөр v) бүлэг чадавхжуулах гэсэн 5 төрлийн зориулалтаар биднийг зээлд хамруулдаг. Иймд надад бол асуудалгүй байсан. Танил бас итгэлтэй хүн учир.

2018 болоод 2019 онд би Хан-Уул дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс эргэн төлөлтгүй халамжийн 1,000,000 төгрөгийн тусламж байдгийг хөгжлийн бэрхшээлтэй дүү нарынхаа халамжийн ажилтнаас мэдээд 2 удаа энэхүү буцалтгүй зээлд хамрагдах гэж хүсэлт өгсөн. Эргэн төлөх шаардлагагүй амар гэж бодсон. Гэтэл эхний удаад заавал зээлийн хамтрагч өрхийн бизнесээ эрхлэх хүнтэй байх ёстой гээд би бүлгийн найзтайгаа хамтрах гэж оролдсон. Гэтэл шалгаруулалтын нэг гишүүн манай найз руу залгаж асуусанд тэр маань над шиг сайн мэдлэг байхгүй нэмэлт мэдээлэл өгч чадаагүй тул тэнцээгүй. Дараагийн удаад намайг нөхрийнхөө нас барсны гэрчилгээг авчир гэсэн. Гэрлүү очиж авах хэрэгтэй гэтэл цагтай нартай ажилладаг гээд татгалзсан. Ингээд ах дүү маань ч 1 сая төгрөг авах гэж их ажил болдог юм байна гээд дахиж хөөцөлдөөгүй. Миний хувьд өрхийн бизнесээ өргөжүүлэх зориулалтаар бизнесийн зээлээс авахаас илүү амьжиргаанд зээлийн хэрэгцээ өндөр байдаг тул бизнестээ яг анхаарах боломж бас байдаггүй. Иймээс одоогоор асаргааны ажил 2 дүүгээ харах, тэтгэмжүүдээрээ болгож байна. Сургалтанд хамрагдах ч цаг бага болсон.

Кейс 4. ЖДҮ-ийн сангийн зээлийн хуваарилалт

...2022 оны 6 сараас зээлийн мэргэжилтний албан тушаалын ажлыг эрхэлж байна. Аймгийн ЖДҮХС-ийн дэд хороо 7 гишүүнтэй, эдгээрийн 4 нь эмэгтэй.

2021 оноос зээлийн хүсэлтийг цахимаар авдаг болсон тул гадны нөлөө, ялангуяа эрх мэдэлтний нөлөө орох нь багассан гэж болно. Жилийн 3%-ийн хүүтэйгээр 5 жилийн хугацаатай, эхний жил 12 сар зээлийн хүүгээс чөлөөлөгдөнө. 2021 онд 2 аж ахуй нэгжид тус сангаас зээл олгогдсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуй, тахианы мах үйлдвэрлэл зориулж 100 сая, 3 суманд ахуйн үйлчилгээний төв байгуулахад зориулж нийт 70 сая төгрөг хуваарилагдсан.

Гол шалгуурын хувьд бид тухайн жилийн дэмжих

салбарын хүрээнд ажлын байр үйлдвэрлэл нэмэгдүүлэх чиглэлд хуваарилалт хийдэг. Дэд хорооны 4 шатлалт үнэлгээг төслийн бүрэн байдал, шаардлага хангах эсэх, тухайн жилийн дэмжих салбарт хамаарч байгаа эсэх, үйл ажиллагаа хэр байгаа гэсэн 5 шалгуураар хийж, хяналтын хорооноос томилогдсон баг газар дээр нь очиж шалгадаг. 2023 онд 20 салбар чиглэлээр зээл олгохоор ярилцаж байгаагаас 18 төсөл ирүүлсэн, эдгээрийн 14 төсөл баталгаажих, 2 төсөл зээлийн эрхээ авсан...

(Аймгийн ЖДҮХС-гийн мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас)

Кейс 5. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зээлийн хуваарилалт

...2021 онд гаргасан Засгийн газрын 340-р тогтоолоор аймаг бүрт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, ХЭДС-гаар дамжуулан 10 тэрбум төгрөг улсын хэмжээнд зарцуулагдахаар зээлийн санд олгогдсон.

2022 онд Зээлийн батлан даалтын сангаас 500 сая төгрөгийн зээлийг ажил эрхлэлтийн дэмжих 68 төсөлд олгосноос 40 нь эмэгтэй зээлдэгч байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 104 сая төгрөгийн зарцуулалт хийгдснээс 8 эмэгтэй зээл авсан. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлд 104 сая төгрөг зарцуулагдаж, 33 ахмад настан зээл авсны 28 нь эмэгтэйчүүд байсан. Малжуулах төслийн хүрээнд 220 сая төгрөг зарцуулагдснаас 44 эмэгтэй зээлд хамрагдсан. Төрийн банкаар дамжин хийгдсэн ба малчдын зээл өмчлөлөөс үл хамаарсан.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр, Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил төсөл төрийн банкаар дамжуулан зээл олгосон. Германы техник хамтын ажиллагаа-Шинэ хөдөө бизнес эрхлэлтийг дэмжих төсөлд 25 хоршоо хамрагдаж байна. Хоршооны гишүүдэд зориулсан цогц сургалтууд зохион байгуулагдаж байгаа бөгөөд 2 сард төслөө бичиж ирүүлсэн 3 хоршоонд буцалтгүй тусламж үзүүлэх юм...

(Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэй хийсэн ярилцлагаас)

Кейс 6. Сайн туршлага: Транс Капитал ББСБ-ын зээлийн шалгуур ба эмэгтэй бичил эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг

...Транскапитал ББСБ Өвөрхангайд 2017 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна. Салбар маань 4 ажиллагсадтай, эдгээрийн 3 нь эмэгтэй.

Зээлийн шалгууртай холбоотойгоор зээлдэгчдэд мэдээлэл бүрэн өгдөг, бусад ББСБ-тай харьцуулалт хүү бага, барьцаа хөрөнгийн уян хатан нөхцөлтэй, зах зээлийн үнэлгээний 60% тооцдог. Эмэгтэй бизнес эрхлэгчдийн барьцаа хөрөнгийн үнэлгээг өсгөдөг. Ингэхдээ нийт хөрөнгийн зах зээлийн

үнэлгээний 65-70% тооцож зээл олгодог. Барьцаа хөрөнгөд үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийг барьцаалах боломжтой. Зээлийн хүү 2,8%, давтан зээлдэгч 2,7% хүртэл буурах боломжтой. Өмнө нь 2,6% хүртэл буурдаг байсан ч Монгол банкны хүү өссөнтэй холбоотой энэ хувиар олгох боломжгүй болсон.

ББСБ зээлийн эдийн засагчдын хөдөлмөрийн гэрээнд ажил үүргийн хүрээнд тухайн харилцагчийг мэдээллээр бүрэн хангах үүргийг тусгасан байдаг.

2017 онд Өвөрхангай аймагт салбар нээгдэн зээлдэгчидтэй харилцаж эхлэхэд барьцаа хөрөнгийн талаар тэдний ойлголт муу, шаардлага хангахгүй хөрөнгүүд их байсан. Жишээ нь оёдолчид тоног төхөөрөмж, бараа материал барьцаалах хүсэлтэй байдаг бөгөөд тэдгээрийг үнэлэн 5-8 сая төгрөгийн зээл олгож байсан. Мөн хувиараа зээлийн шаардлага хангахгүй тохиолдолд бизнесийн зээлийг бүлгээр (3-5 хүн) өгөх арга хэмжээ авч нэг бүлэгт 5 сая хүртэлх зээл олгож байсан...

Зээлийн мэдээлэл, материал бүрдүүлэлт

...Зээлийн мэдээллийн хүртээмжийн хувьд аймагтаа хамгийн хүртээмжтэй олон бүтээгдэхүүнтэй, харилцагч бүрт тохирсон бүтээгдэхүүнийг гаргах боломжтой.

Банкнаас зээл авч чадаагүй харилцагчид их байдаг. Нэг харилцагчид зарцуулах хугацаа нь зээлдэгч материалаа сайн бүрдүүлсэн болон давтан зээлдэгчид, түүнчлэн тухайн үеийн ачаалал зэргээс хамаарч хамгийн багадаа ажлын 8 цагийн дотор, хамгийн уртдаа 2 өдрийн дотор байдаг. Нөгөө талаас зээлийн хүсэлт гаргагчид зээлийн эдийн засагчид болон бусад зээлийн мэргэжилтнүүдийг харилцаа хандлага болон тухайн үеийн ачааллаас үүдэн шүүмжлэх хандлагатай байдаг. Мөн зээлийн шалгууруудтай бүрэн танилцаагүйн улмаас материал дутуу бүрдүүлэн цаг алдан үл ойлголцол үүсэх тохиолдлууд байдаг. Зээлийн эдийн засагчийн зүгээс зээлдэгчдийг орлого нотлохдоо дансны хуулга болон гүйлгээний утган дээрээ анхаарах, давхар хар дэвтэр хөтлөлт дээр анхаарахыг сануулдаг. Ихэнх жижиг бизнес эрхлэгчид дээрх алдааг гаргадаг бөгөөд санхүүгийн байгууллагуудад аман нотолгоо өгөхийг хүсдэг. Ингэснээр бизнесийн зээл авах эрх нь хязгаарлагдмал болдог.

Зээл авч чадахгүй байгаа харилцагчдийн хувьд зээлийн ангилал буурсантай холбоотой шалтгаан зонхилдог. Энэ нь 2 шалтгаантай.

1. Зээлдэгчийн хариуцлага зээлээ хугацаанд бүрэн төлөөгүй.
2. Санхүүгийн байгууллагуудын зээлийн эдийн засагчид зарим тохиолдолд алдаа гаргасан байдаг. Бага дүнгээр үлдэгдэлтэй байхад нь эсвэл бага дүнгийн зөрүүтэй байхад эрт сануулж арга хэмжээ хурдан авалгүйгээр

хугацааг хэтрүүлэн зээлийн ангилал бууруулсан байдаг.

Бас нэг шалтгаан бол зээлдэгч нар орлогоо нотлож чаддаггүй. Дээр дурьдсанчлан бизнес эрхлэгчид орлогоо бүртгэж, баталж чаддаггүй. Гэсэн хэдий ч тухайн зээлдэгчийн ангилал буурсан шалтгааныг судалж үзэж шалтгааныг тогтоодог. Мөн холбоотой байгууллагуудаас шалтгааны тодорхойлолт авдаг. Жишээ нь цалингийн асуудлууд их байдаг. Байгууллага нь хугацаандаа цалин өгөөгүй, өөр бусад зүйлээр бартердах, гэнэтийн зүйлс тохиолдох гэх мэт. Ковид19 цар тахалын үеийн эдийн засгийн нөлөө байсан. Ийнхүү шалтгааныг нь тодруулан тухайн харилцагчийн нөхцөл байдалд тохирсон гаргалгаа гаргаж өгдөг.

Харилцагчид ээлтэй ажилладаг гэж дүгнэдэг, манай харилцагч болохын тулд зээлийн эдийн засагчтай цахимаар, утсаар болон биечлэн холбогдох боломжтой...

(Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг БСББ-ийн ажилтантай хийсэн ярилцлагаас)

5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү баримтын болон кейс судалгааны үр дүнд үндэслэн бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд санхүү, зээл хүртээмжгүй байгаа учир шалтгааны талаар дараах гол дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Зээлийн шалгуурууд нь бичил бизнес эрхлэгчдийн онцлогт тохироогүй байна. Бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд банк, санхүүгийн холбогдох байгууллагуудын зүгээс тэдгээрт чиглэсэн бичил зээл, санхүүгийн дэмжих тусгай арга хэмжээ байхгүй байна. Засгийн газраас АХБ-ны санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ХААН банк, Төрийн банкаар дамжуулан эмэгтэйчүүдийн дэмжих зээлийг олгож байгаа боловч бичил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд тусгайлан зориулагдаагүй байна.
- Арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлж буй тусгай сангийн эсвэл олон улсын санхүүгийн байгууллагуудын мэдээллүүд хуучин, шинэчлэгдэхгүй байна. Улмаар эмэгтэй бизнес эрхлэгчдэд шинэ мэдээлэлтэй болохын тулд илүү их цаг гарган судлах шаардлагатай болдог байна. Мөн зээл, санхүүжилттэй холбоотой бүхий л мэдээллийг нэг дороос авах боломжийг сонирхогч бүх талуудад бүрдүүлж

чадаагүй байна.

- Төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдахад тодорхой шалгуур тавигддаг хэдий ч засаг, захиргааны нэгжийн төлөөлөл бүхий дэд зөвлөлөөр дамжиж байгаагаас субъектив хүчин зүйл нөлөөлж байна.
- Барьцаа хөрөнгөнд үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө гэсэн уламжлалт эх үүсвэр шаардаж байна. Гэтэл зах зээлийн эдийн засгийн өнөөгийн нөхцөлд биет бус хөрөнгийн болон итгэлцлийн өөр хувилбарууд, ялангуяа бичил бизнес эрхлэгчдийн хувьд үгүйлэгдэж байна.
- Зээлийн шалгуур хангаагүй эмэгтэйчүүдэд зээлийн үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн болон төрийн үйлчилгээний байгууллагаас өөр бусад боломжит зээлийн хувилбаруудын талаар мэдээлэл өгөхгүй байна. Улмаар ам дамжсан мэдээлэлд хөтлөгдөн, зээл авах боломжийн гадна үлдэж байна.
- Бичил, өрхийн бизнес эрхэлж буй эмэгтэйчүүд боломжит зээлийн бүтээгдэхүүнүүдийн талаар аливаа танил, найз нөхөд, хамт олон, нийгмийн сүлжээгээс авч байна. Зарим эмэгтэйчүүд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв (БЭЭТ)-өөр дамжуулан мэдээлэл авдаг ч санхүү, зээлийн бодит дэмжлэг авахад нэмэлт тус дэм шаардлагатай байна. Иймд БЭЭТ-ийн зүгээс эмэгтэйчүүдэд мэдээлэл олгохын зэрэгцээ төв холбон зуучилж зээлд хамруулсан сайн туршлагатай болж байна.
- Арилжааны банкууд зээлийн төлөвлөгөө биелсэн тохиолдолд зээл өгөх сонирхолгүй болдог талаар ч эмэгтэйчүүд, мэргэжилтэнүүд онцолж байна. Улмаар бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд цаг хугацааны алдагдалд давхар өртөж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн хуваарилалт нь төлөвлөлт дээр үндэслээгүй, уриа тунхаглалын шинж бүхий агуулгаар явж байгаа нь мөн чанартаа шинээр ажлын байр бий болгох хөрөнгө оруулалтын болон бичил

бизнесийг дэмжихэд үр нөлөөгүй байна.

- Гүр бүл, өрхийн асаргааны хариуцлагыг бизнес эрхлэгч эмэгтэйчүүд голдуу үүрч байгаа тул хөдөлмөр халамжийн хэлтэс зэрэг үйлчилгээнд тухайн хүнд тохирсон дарамтгүй шалгуурыг тавьж зорилтот бүлэгтээ нийцсэн шаардлагаар эргэн төлөлтгүй зээлийг зохицуулах хэрэгцээ гарч байна.
- Санхүүгийн байгууллагууд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан тусгай бүтээгдэхүүнүүдийг багцлан судалж, цаглабараар тоймлон дүгнэх хэрэгтэй байна.

Зөвлөмж

Засгийн газраас хэрэгжүүлж буй ХЭДС болон ЖДҮС-д бичил зээл, санхүүжилтийг доорх онцлог, зориулалтад нийцүүлэн бодиттойгоор хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Хөрөнгийн барьцаа, баталгаа шаардахгүй байхаар зээлийн онцлогийг баталгаажуулах;
2. Ажилгүйдэл, ядуурал хамгийн өндөр, зах зээлээс хол эсвэл зах зээл хөгжих боломжгүй болон хүн амын нягтрал сийрэг аймаг, сумын хүн амыг зээлийн зорилтод бүлэг болгон сонгож тусгай шаардлагаар ашиглах;
3. Эмэгтэйчүүд, ядуус өөрсдөө зориулсан орлого бий болгох эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох санал, санаачлагын дэмжих;
4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журамд зээл олгох хэлбэрийг илүү нарийвчилж тодорхойлох;
5. ЖДҮ хөгжүүлэх сангийн зээлийг дамжуулан зээлдүүлж буй санхүүгийн байгууллагуудын тус тусын журманд нэмэлт шаардлагатай уян хатан байдлын талаар оруулах;
6. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хамт олны хүрээлэл, нийгмийн сүлжээ, мэдээлэл солилцох орчинг зөвхөн мэдээллээр хангах бус зээлд хамрагдах байдлыг нь дэмжин холбох байдлыг БЭЭТ-ийн сайн туршлагад үндэслэн санхүүгийн

байгууллагуудад санал болгох.

Эцэст нь, зорилтод бүлэг, зорилтод үйл ажиллагаанд зарцуулж буй бодлого, хөтөлбөрийн санхүүжилт, төсвийн хуваарилалт, зарцуулалтыг ил тод мэдээлэх, тайлагнах, хөндлөнгийн хяналт-үнэлгээ хийх нэгдсэн удирдамжийг аймаг/дүүрэг, сум/хороонд хүргүүлэн, үр дүнг холбогдох албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлээр үнэлж байх шаардлагатай.

Төгсгөлийн оронд, Арилжааны банкнуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд бичил зээлээр дамжуулан эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санал, санаачлагад нэгдэхийг уриалж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Азийн сан, 2022. Монгол Улсын санхүүгийн салбарын жендэрийн хүртээмжтэй байдал болон эмэгтэйчүүдэд чиглэсэн санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх гарын авлага, Улаанбаатар

Азийн сан, Жендэрийн Үндэсний Хороо, 2023. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах нь

Дэлхийн банк, 2017. Findex Data.

Монголбанк, 2023. Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээл, хүйсээр www.mongolbank.mn

ОУСК, 2014. Монгол Улс дахь ЖДҮ ба Эмэгтэй ЖДҮ эрхлэгчид, Олон улсын санхүүгийн корпораци

Цахим хуудас

Үндэсний статистикийн хороо. Нэгдсэн мэдээллийн сан, <http://1212.mn>

https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/09/Covid-19-Impact-Assessment-on-Micro-and-Small-scale-Women-Business-Enterprises-in-Mongolia_MG.pdf

<https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol201830.pdf>